

# **“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС” ХК**

Дундговь аймаг, Сайншагаан сум,  
7-р баг, Нарлаг

## **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

Дугаар 2026/ 02

### **ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.9, 62.1.15 дахь заалт, 64 дугаар зүйл, 65 дугаар зүйлийн 65.3, 65.4 дэх заалт, 67 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1. “Мандалговь-Импекс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4-р сарын 29-ны 15 цагт УБ хот, БЗД, 6-р хороо, Энхтайвны өргөн чөлөө гудамж, 57/7 тоот хаягт байрлалтай ажлын байранд хурлыг товлосугай.
2. Тус ээлжит хурлаар дараах асуудлыг авч хэлэлцсүгэй.
  1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны талаарх болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх;
  2. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг батлах
  3. 2026 онд шаардагдах төсөв, түүнтэй холбоотойгоор зээл авах тухай
3. Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хавсралт №1-ээр баталж, 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн дотор багтаан Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэх, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар”-ыг Хавсралт №2-оор баталж 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, мөн уг зарыг 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр анх мэдээлсэний дагуу дахин хурлын зар хүргэх, Бүртгэлийн өдрийг 4-р сарын 14-р, Саналын хуудас хүлээн авах өдрийг 2026 оны 4-р сарын 21-ны 17 цагаар тасалбар болгон тогтсугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг "Хавсралт 6"-р батлаж, 2026 оны 03 дугаар сарын 30-ны дотор багтаан хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер диллерийн компанид хүргүүлсүгэй.
5. Хурлыг зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ын дарга О.Мөнх-Эрдэнэ, гишүүдэд Д.Одгэрэл, С.Баярцэцэг нарыг томилсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Г.Отгонжаргал, гишүүнээр Б.Нямцэрэн нарыг томилсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал авах хуудсыг "Хавсралт 3,4"-р баталсугай.
8. Хурлын дэгийг "Хавсралт 5"-р баталсугай.

ТУЗ-ийн ДАРГА

**МАНДАЛГОВЬ  
ИМПЕКС  
ХК**

2012294-ГТА010740  
0319090004

*О.Мөнх-Эрдэнэ* **О.МӨНХ-ЭРДЭНЭ**